$$k_1 = \frac{\alpha}{\sqrt[m]{\sum N_p}} = \frac{6.3}{\sqrt[4]{236364}} = 0.286$$

Хамгийн их сунгах хүчдэл σ

$$\sigma_r = \bar{\sigma}_r \times p \times k_b = 2.75 \times 0.6 \times 1 = 1.65 \text{ МПа}$$

Материалын гулзайлтын үеийн бат бэх $R_n = 2.205$ МПа

$$R_n = R_0 \times k_1 \times k_2 \times (1 - v_r \times t) = 9.5 \times 0.286 \times 0.98 \times (1 - 0.1 \times 1.71) = 2.205 \text{ МПа}$$

Бат бэхийн тооцоолсон итгэлцүүр $K_{расч} = 1.34$

$$K_{\text{расч}} = \frac{R_n}{\sigma_r} = \frac{2.205}{1.65} = 1.34$$

Бат бэхийн шаардлагатай итгэлцүүр $K_{\text{тр}} = 1.000$

Бат бэхийн нөөц $(K_{\text{расч}} - K_{\text{тр}}) / K_{\text{тр}} * 100\% = 33.64\%$ (Хангалттай байна.)

$$\frac{K_{\text{расч}} - K_{\text{тр}}}{K_{\text{тр}}} \times 100\% = \frac{1.34 - 1}{1} \times 100\% = 33.64\%$$



*Авто замын зураг төслийн
“Засмал Зам” ХХК*

БҮЛЭГ-5. УС ЗҮЙН ТООЦОО

БҮЛЭГ 5

Ус зүйн тооцоо

5.1 Ус хураах талбай

Дархан – Уул аймаг Хонгор суманд байрлана. Ус хураах талбайг 2 хэсэгт хувааж авлаа.

1. Ус хураах талбай 1 нь I хэсгийн км 2+091.3 дээрх хоолойд хамаарна. Ус хураах талбай 1 болон 2-н нийлбэр хэмжээгээр авлаа.
2. Ус хураах талбай 2 нь II хэсгийн км 0+254.41, км 1+948.5, км 2+091.31 дээрх хоолойд хамаарна.



3.

авав.

Зураг 1 Ус хураах талбайн зураг




Зураг 2 Ус хураах талбайн зураг

5.2 Авто замын уур амьсгалын нөхцөл

Авто зам барихаар төлөвлөж буй газар нутаг нь Монгол орны авто замын уур амьсгал-геотехникийн нөхцлийн II А бүсийн ойт хээрийн чийглэгдүү, нэн хүйтэн, хахир дэд бүсэд хамаарч байна.

Энэ бүсийн онцлог нь Авто замын уур амьсгалын мужлалаар Хангайн өндөр уулын нэн хүйтэн-чийглэгдүү байх уулт хээрийн хахир газрууд багтдаг. Мөн уур амьсгалын хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөлт-гэсэлттэй. Уулархаг хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, хөндий дагасан салхитай, хахир хүйтэн жаварлаг байх дэд бүсэд хамаарч байна.



Зураг 3

5.3 Зарцуулгын тооцооллын аргачлал

Хээрийн судалгааны явцад замын зурвасыг байр зүйн зурагт буулгаж, сайр жалгын огтолж байгаа цэгүүдийг байршуулж, ус хураах талбайн ерөнхий байдал /ургамалшилт, хөрсний бүтэц, ус хураах талбайн өргөн, урт болон голдирлын муруй, эргийн байдал зэрэг/-ын бичиглэл хийлээ.


Судалгаанд хамрагдаж байгаа замын ус хураах талбайн хэмжээ, дундаж өндөр, жалга болон хажуу бэлийн дундаж хэвгий болон сайр жалгын уртыг google earth –ийн гадаргууг ашиглаж тодорхойлж гаргав.

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт “Усз үйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм “/БНБД 2.01.14-86/ - с авлаа. Хур борооны үерийн их урсцын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийв.

5.4 Хоногийн хамгийн их тунадас түүний хангамшил

“Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” /УЦУХ 1994 он/ хуудас 136 зураг 29)-д дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн хангамж бүхий хэмжээг уг бүсэд $H_{1\%}=120$ мм гэж тодорхойлсныг цаашдын тооцоонд хамруулан хэрэглэв.

1%-ийн хангамж бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээний мужлал



Зураг 4 “ Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд ”

/УЦУХ 1994 он/ хуудас 136, 29-р зураг

5.5 Зарцуулгын тооцоо

200 км²-с бага ус хураах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсцын тооцоог (“Ус зүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрэм” /БНБД 2.01.14-86./)-д заасны дагуу хур борооны эрчимжилтийн аргыг ашигласан болно. 200 км² – с бага ус хураах талбайн усны зарцуулгыг III төрлийн дараах томъёогоор тооцно. /хязгаарын эрчмийн тооцоо/

$$Q_{p\%} = q'_{1\%} * \varphi * H_{1\%} * \delta * \lambda_{p\%} * A \quad /\text{Томьёо 1}/$$

Үүнд:

- $Q_{1\%}$ - Хамгийн их зарцуулга м³/сек
 - $q'_{1\%}$ - жилийн урсцын хэтрэх магадлалын хамгийн их модуль / м³/с * км² / хавсралт хүснэгт 1 – с авах
- φ - Урсцын хуримтлалын коэффициент / Томьёо 2 – с /
- $H_{1\%}$ - 1% хангамжийг давж гарах хоногийн хамгийн их тунадас, мм /Ойролцоох цаг уурын станцын өгөгдлөөр болон нормоос авна.
- δ -нууршил, ой, намагшилтын коэффициент
- $\lambda_{p\%}$ - 1 % ийн хангамшлаас P рүү шилжүүлэх коэффициент /хүснэгт -2 авах/
- A – Ус хураах талбай км²

5.5.1 Томьёоны өгөгдөл

1. $q'_{1\%}$ - хажуу энгэрээс ус урсан ирэх хугацаа болон жалгын хэлбэр зүйгээс хамааруулан / Φ_r / Хавсралт хүснэгт 1-с авна.
2. Хажуу энгэрээр ус урсах хугацаа/: $\tau_{\text{сек}} \text{ МИН}$
 - Ойн бүсэд намагшил 20% -иас бага голд 60 мин
 - 20% -40% намагшилтай голд 100 мин
 - 40% -иас намагшилтай голд 150 мин
 - Ойт хээрийн бүсэд 60 мин
 - Хээр, говийн бүсэд 30 мин
 - Уулархаг нутагт 10 минутаар авна.

$$3. \varphi = \frac{C_2}{(A+1)^{n_3}} * \varphi_0 * \left(\frac{I_{\frac{1}{2}}}{50}\right)^{n_2} \quad /\text{Томьёо 2}/$$

Үүнд:

- C_2 - Эмпириз коэффициент (ойн бүсэд 1.3, бусад бүсэд 1.2-оор авна)
- φ_0 - $A=10$ км² ус хураах талбайтай, дундаж налуу нь $I_B = 5\%$ бол φ_0 , n_2 –ийг хөрсний төрлөөс хамааруулан хавсралт хүснэгт 2 - с авна, n_3 –ийг (ойн бүсэд 0.07, бусад бүсэд 0.11-оор авна)
- I_B – Хажуу энгэрийн дундаж хэвгий

$$4. \Phi_r = (1000 * L) / (m_p * I_p^m * A^{1/4} * (\varphi * H_{1\%})^{1/4}) \quad / \text{Томьёо 3} /$$

Үүнд:

- Φ_r - Хажуу энгэрийн хэлбэр зүй
- L - Хажуу энгэрийн дундаж урт, км
- m_p - Голдирлын гадаргуун барзгаржилтын коэффициент /Хүснэгт 3-с /
- I_p - Голдирлын дундаж хэвгий %₀

$$5. \delta = 1 / (1 + C_o A_{o3}) \quad / \text{Томьёо 4} /$$

Харьцангуй нууршил A_{o3} -ын мэдээлэл байгаа тохиолдолд C_o –ын утгыг байгалийн бүх бүсэд 0.11-ээр, нууршлын дундаж жигнэсэн мэдээлэл A'_{o3} байгаа тохиолдолд C_o –ын утгыг ойн болон ойт хээрийн бүсэд 0.2-оор тал хээрийн бүсэд 0.4 –ээр тус тус авна.

Зарцуулгын тооцоо

№	Байршил	A (км ²)	q, l% (м3/сек*км ²)	φ	НП%	δ	λр%	Q _{1%} (м ³ /сек)	Q _{2%} (м ³ /сек)	Q _{5%} (м ³ /сек)	Хоолойн хэмжээ
1	0+254.410 II Хэсэг	1.300	0.110	0.20	130.00	1.00	1.00	3.729	3.356	3.095	Φ=1000*2
2	1+950.00 II Хэсэг	1.400	0.100	0.20	130.00	1.00	1.00	3.633	3.270	3.016	Φ=1000*2
3	2+173.00 II Хэсэг	1.600	0.090	0.20	130.00	1.00	1.00	3.704	3.334	3.075	Φ=1000*2
4	2+091.31 I Хэсэг	1.900	0.069	0.22	130.00	1.00	1.00	3.705	3.335	3.075	Φ=1000*2

1. j- Урсцын хуримтлалын коэффициент

№	A, км2	IB, %	C2	n2	n3	φ ₀	φ	δ=1
1	1.300	80	1.2	0.9	0.11	0.12	0.200577	
2	1.400	80	1.2	0.9	0.11	0.12	0.19964	
3	1.600	80	1.2	0.9	0.11	0.12	0.19789	
4	1.900	90	1.2	0.9	0.11	0.12	0.217392	

2. Фг - Хажуу энгэрийн хэлбэр зүй

№	A, км2	L, км	Ip, %	m	mp	φ	НП%	Φ _r
1	1.300	1.92	28	0.3333	11	0.200577	130	23.825
2	1.400	2.1	28	0.3333	11	0.19964	130	25.610
3	1.600	2.3	28	0.3333	11	0.19789	130	27.188
4	0.67	2.63	45	0.3333	11	0.217392	130	32.228

q 1% -жилийн урцын хэтрэх магадлалын хамгийн их модуль / м3/с * км2 /

№	Муж	тсек	φr	q 1%
1	3	30	23.825	0.11
2	3	30	25.610	0.1
3	3	30	27.188	0.09
4	3	30	32.228	0.069

Нэг хувийн хангамжтай урцыг өөр хангамжид шилжүүлэх коэффициент λ_p %

Мужийн дугаар	I	II	III	IV	V
3	1	0.9	0.83	0.78	0.75

6.5 Өнгөрүүлэх чадварын тооцоо

6.5.1 1% налуутай, $\Phi=1000$ хоолойн усыг өнгөрүүлэх чадвар нь $2.03 \text{ м}^3 / \text{сек}$ байна.

Pipe Flow Advisor www.pipeflow.co.uk 1/3/2022

Registered copy: Licensed by www.pipeflow.co.uk

Rect. tank
 Circular tank
 Cylinder
 Sphere
 Cone (frustum)
 Rect. hopper
 Flow from Weirs
 Manning calculator
 Pipe (part full)
 Pipe (full)
 Rect. tube (part full)
 Rect. tube (full)
 Rect. channel
 Flat bottom channel
 Vee channel

Pipe details Metric Imperial

Manning's coefficient
 0.014 Concrete (average)

Length in meters
 20 m

Internal diameter
 * 1000 mm

Fluid depth (uniform flow)
 * 750 mm

Drop in meters
 0.2 m

Increase
 Reduce

* dimensions in mm

Results

- Water flow rate
- Water depth
- Volume and weight
- Length expansion

Fluid cross section area	0.631852 m ²	Fluid velocity	3.213 m/s
Wetted perimeter	2094.395 mm	Fluid surface width	866.025 mm
Hydraulic radius	301.687 mm	Froude number	1.201 - rapid flow

Water flow rate
 2.030 m³/sec Max. Flow

Slope ratio (angle)
 0.010000 (0.573°)

Calculate water flow rate

Тайлбар бичиг

№	Байршил	Бодит усны зарцуулга $Q_{2\%}$		$Q_{5\%}$ Өнгөрүүлэх боломжит зарцуулга ($M^3/сек$)	Хоолойн хэмжээ
		A (KM^2)	Тайлбар ($M^3/сек$)		
1	0+254.410 II Хэсэг	1.300	3.356	4.06	$\Phi=1000*2$
2	1+950.00 II Хэсэг	1.400	3.270	4.06	$\Phi=1000*2$
3	2+173.00 II Хэсэг	1.600	3.334	4.06	$\Phi=1000*2$
4	2+091.31 I Хэсэг	1.900	3.335	4.06	$\Phi=1000*2$

УС ЗҮЙН ТООЦООЛЛЫН

ХАВСРАЛТ 1

Урсцын коэффициент, тунадасны хувиар /ф Н. %/ гаргасан борооны үерийн хамгийн их урсцын модуль, q₁%

Хүснэгт 1

Мужийн дугаар, БНБД 2.01.14-86-ийн 19-р хавсралтаар	Хур борооны үргэлжлэх хугацаа мин Цсек	Фг-Гадаргын хамгийн өндөр цэгээс байгуулаж хүртлэх борооны усны урсах хугацаа															
		1	5	10	20	30	40	50	60	70	80	90	100	150	200	250	300
I	10	0.33	0.19	0.14	0.067	0.062	0.048	0.039	0.032	0.030	0.026	0.023	0.022	0.016	0.012	0.010	0.0083
	30	0.22	0.14	0.10	0.071	0.055	0.043	0.038	0.031	0.028	0.025	0.022	0.021	0.016	0.012	0.010	0.0082
	60	0.12	0.091	0.074	0.058	0.046	0.038	0.033	0.029	0.026	0.024	0.022	0.020	0.016	0.012	0.010	0.0080
	100	0.079	0.066	0.055	0.046	0.038	0.031	0.030	0.026	0.024	0.022	0.021	0.019	0.016	0.011	0.0098	0.0079
	150	0.060	0.050	0.045	0.038	0.033	0.030	0.028	0.025	0.023	0.021	0.020	0.018	0.014	0.011	0.0093	0.0076
	200	0.050	0.046	0.042	0.035	0.031	0.028	0.026	0.024	0.022	0.020	0.019	0.018	0.019	0.011	0.0089	0.0072
II, III	10	0.64	0.32	0.22	0.14	0.10	0.098	0.060	0.048	0.043	0.035	0.032	0.029	0.017	0.012	0.0098	0.0078
	30	0.50	0.21	0.16	0.11	0.095	0.090	0.055	0.045	0.040	0.033	0.030	0.026	0.017	0.011	0.0096	0.0077
	60	0.17	0.14	0.11	0.085	0.069	0.056	0.046	0.040	0.036	0.029	0.028	0.024	0.016	0.011	0.0095	0.0076
	100	0.12	0.10	0.085	0.066	0.056	0.048	0.042	0.035	0.033	0.028	0.025	0.023	0.015	0.011	0.0093	0.0075
	150	0.10	0.083	0.071	0.056	0.048	0.040	0.036	0.032	0.030	0.025	0.023	0.021	0.014	0.011	0.0091	0.0073
	200	0.093	0.076	0.065	0.051	0.044	0.037	0.035	0.029	0.026	0.023	0.022	0.020	0.014	0.010	0.0089	0.0072
IV	10	0.72	0.52	0.35	0.30	0.13	0.089	0.071	0.055	0.045	0.038	0.034	0.030	0.019	0.013	0.010	0.0085
	30	0.42	0.33	0.23	0.14	0.11	0.079	0.063	0.050	0.048	0.036	0.032	0.028	0.017	0.012	0.010	0.0083
	60	0.35	0.30	0.15	0.10	0.079	0.068	0.052	0.043	0.038	0.033	0.029	0.027	0.017	0.012	0.010	0.0081
	100	0.22	0.14	0.11	0.079	0.060	0.056	0.044	0.017	0.033	0.030	0.026	0.024	0.016	0.011	0.010	0.0081
	150	0.16	0.14	0.098	0.069	0.056	0.044	0.035	0.033	0.030	0.028	0.024	0.022	0.015	0.011	0.0095	0.0079
	200	0.013	0.011	0.097	0.065	0.056	0.041	0.032	0.031	0.028	0.025	0.022	0.020	0.014	0.011	0.0093	0.0076

Томьёо 2 –ийн φ_0 , $n2$ параметруудийн утга

Хүснэгт 2

Бүслэл	Хөрсний хэв шинж	Хөрсний хэв шинж, механик бүтцээс хамаарах параметрийн утга φ_0 , $n2$					
		II анги хүнд шавранцар		Шавранцар, дунд зэргийн шавранцар		Ан цавт цэрдэн элсэнцэр хөрс	
		φ_0	$n2$	φ_0	$n2$		
Тайга ба ойн бүс	Ул чулуулаг дээрх өгөршсөн хөрс /цэвдэгт тайгыг оролцуулан/, тайгын, намгийн, өгөршсөн хөрсүүд, ойн саарал хөрс	0.42	0.50	0.28	0.65	0.23	0.80
Ойт хээр	Ойн өгөршсөн саарал хөрс, нягт ул чулуулаг дээрх, зузаан хар шороо, цайвар ба хар-саарал өгөршсөн шүлтлэг хар шороо, хар хүрэн хөрс Шүлтлэг хар шороо	0.56	0.50	0.38	0.65	0.30	0.80
Хээр, хуурай хээр	Хүрэн ба карбонаттай саарал хөрс	0.66	0.60	0.54	0.70	0.27	0.90
	Шар тойром	0.59	0.70	0.22	0.85	0.14	1.00
		0.18	0.80	0.10	0.90	0.05	1.00
		0.29	0.90	0.14	0.90	0.12	1.00
		0.30	1.00	0.20	1.00	-	-

Голдирлын налуугаас хамаарсан гадаргуун барзгаржилтын коэффициент дараах хүснэгтээс авна.

Хүснэгт 3

Голдрил татмын тодорхойлол	m	t_p м/мин
Дундаж налуу $I_p < 3.5\%$ их түр урсацтай гол болон хуурай сайрууд	1/3	11
Том болон дунд хэмжээний голын голдирлын урсгал хэсэгчлэн ихсдэг, үе үе хуурайшдаг, үерийн үед ихээхэн хэмжээний ус урсадаг тохиолдолд	1/3	9
Урсгалд саад болох зүйл ихтэй ба тахиралдсан хуурай сайрууд	1/3	7
$I_p > 3.5\%$ дундаж хэвгийтэй түр урсацтай гол, хуурай сайрууд	1/3	10

Нэг хувийн хангамжтай урсцыг өөр хангамжид шилжүүлэх коэффициент $\lambda_p\%$

Хүснэгт 4

Мужийн дугаар	I	II	III	IV	V
1	1	0.86	0.81	0.75	0.72
2	1	0.87	0.78	0.68	0.68
3	1	0.90	0.83	0.78	0.75
4	1	0.83	0.73	0.66	0.62
5	1	0.87	0.79	0.72	0.69
6	1	0.83	0.73	0.65	0.61

БҮЛЭГ 6

Төсвийн тооцоо болон ажлын тоо хэмжээ

6.1 Зам барилгын ажлын төсвийн тооцоо

1. Төсвийн тооцоог Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг үндэслэн, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7-дугаар сарын 31-ний өдрийн 256-дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019” –ын дагуу төсөв зохиох компьютерийн RBC-Estimator программ ашиглан гүйцэтгэлээ.

2. Зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын тарифт цалинг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07-р сарын 31-ий өдрийн 256-р тушаалын дагуу тооцлоо.

3.Зам барилгын ажлын механизмын операторчидын цалинг машин механизмын зардалын дүнгээс 8.7 %-иар бодож төсөвт тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд машин механизмын зардалын дүнгээс хасаж тооцно.Тээврийн жолоочийн цалинг мөн үүний адил тооцно.

4. Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 зүйлд заасны дагуу ажил олгогч /компани/-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.5 %-иар, Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэлийн хувь хэмжээг 3%-иар /нийтдээ 14.5 %/ тус тус тооцож, төсөв зохиов.

5. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн 187 тоот тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар бодож тооцлоо.

6. Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг Зам Тээврийн Хөгжлийн яамны сайдын 2017 оны 10 сарын 13-ы өдрийн 212 тоот тушаалаар батлагдсан машин механизмын нэг машин цагийн жишиг нормын дагуу, Авто машинаар ачаа тээвэрлэх зардлыг ЗТАЖ-ын сайдын 2008 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн 136 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифын дагуу, тус тус тооцов.

7. Захиалагчийн хяналтын зардлыг барилга угсралтын ажлын нийт өртөгийн 2%, Магадлашгүй ажлын зардлыг шууд зардалын 2%, Нэмэгдсэн өртгийн албан татварыг “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” Монгол улсын хуулийн 11-р зүйлийн 11.1-р заалтын дагуу барилга угсралтын ажлынз ардлын 10%-иар тооцож төсөвт тусгалаа.

8. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын хувцасны элэгдэлийн зардлыг ЗТБХБЯ-ын сайдын 2012 оны 181-р тушаалын дагуу нийт цалингийн дүнгийн 13.6 %-иар тооцлоо.

9.Норм нормативын зардалыг Авто замын тухай хуулийн 8.4.1-д заасны дагуу барилга угсралтын ажлын дүнгийн 0.4%-иар тус тус тооцлоо

Техникийн нөхцөл бусад

баримт бичиг



Техникийн нөхцөл

Дугаар: 2021-D-02

2021-09-06-ны өдөр

Захиалагч байгууллага: “ЗАСМАЛ ЗАМ” ХХК

Хэрэглэгчийн нэр: ЗАХИРАЛ Н. НЯМСҮРЭН

1. Холбооны хэрэгцээ: ХУДАГ СУВАГЧЛАЛ ХҮЧИТГЭХ.

Барилгын байршил: ДАРХАН-УУЛ АЙМАГ ХОНГОР СУМЫН ХҮРЭЭНД

2. Техникийн үндсэн нөхцөл:

- 2.1. ТБУХ2 3-с ТБУХ2 4-р худаг, ТБУХ1 1-с ТБУХ1 2-р худгууд хооронд авто замын ажлын трасст орсон сувагчлалыг хүчитгэж хамгаалах.
- 2.2. Авто зам хөндлөн гарч байгаа олон улсын транзит шилэн кабелийг 100 мм диаметртэй төмөр хоолой хийж хамгаалах. 100 мм диаметртэй төмөр нөөц хоолой тавих.
- 2.3. Харилцаа холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.

3. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 3.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 6668:2017, MNS 6581:2016 тоот ерөнхий шаардлагуудыг баримтлан гүйцэтгэх.
- 3.2. Кабель шугамын байгууламжинд ажиллах зөвшөөрлийг Ерөнхий инженер Э.Мөнхбаяр (утас : 70373890 , 99028828 , 88086011) – аас авч ажлыг эхэлнэ. Зөвшөөрөл аваагүй тохиолдолд ажлыг зогсоож захиалагч болон гүйцэтгэгчид хариуцлага тооцно.


4. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 4.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцөлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ДУАГазрын ШКХ-ийн инженер С.Чинбат-р (утас: 70373222 , 99027538) хянуулан баталгааг авсан байх.
- 4.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах тухайн ШКХэсгийн инженерээр шалгуулан далд ажлын ажлын акт үйлдэж, хүлээн авах ажлын актанд хавсаргах


- 4.3. Угсралтын газар шорооны ажил эхлэхийн өмнө хотын инженерийн шугам сүлжээний техникийн ашиглалт хариуцдаг мэргэжлийн байгууллагуудад трассын зургийг хянуулан зөвшөөрөлцсөн байх.
 - 4.4. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ДУАГазрын ерөнхий инженерээс зөвшөөрөл авч харъяалагдах ШКХ-ийн инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.
 - 4.5. Угсралтын ажлыг гадна агаарын температур -5 градусаас илүүгүй хүйтний нөхцөлд гүйцэтгэх
 - 4.6. Угсралтын ажлын явцад захиалагч, ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хянуулсан байх.
5. Техникийн нөхцлийг "Засмал зам" ХХК-н захирал Н. Нямсүрэн-н гаргасан 2021 оны 08 сарын 23-ны өдрийн № 112/21 албан тоотыг үндэслэн 2021 оны 09-р сарын 06-ны өдөр олгов.
 6. Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

ЖИЧ: Газар шорооны ажил эхлэх үед манай компанид мэдэгдэх.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙГ ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:


.......... Э.МӨНХБАЯР

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙГ БОЛОВСРУУЛСАН:
ШКХ-ИЙН ИНЖЕНЕР:

.......... С.ЧИНБАТ

Хавсралт № 1

Дархан-Уул аймаг Хонгор сумын төвийн 5.5 км авто замын ажлын трасс-д орсон хэсэг.



Тайлбар:



Ашиглалтанд байгаа худаг




Ашиглалтанд байгаа сувагчлал



Хүчитгэл хийх сувагчлалын хэсэг

Хавсралт № 2

Дархан-Уул аймаг Хонгор сумын төвийн 5.5 км авто замын ажлын трасс-д орсон хэсэг.



Тайлбар:



Олон улсын транзит шилэн кабель




Шинээр хийх нөөц хоолой



Хамгаалалтын төмөр хоолой хийх хэсэг

БАТЛАВ, ДСЦТС ХК-ИЙН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Б. БАТЖАРГАЛ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 38 / 458 – 2021 - 09

2021 оны 09 сарын 15-ны өдөр

Дархан-Уул аймаг

1. Хэрэглэгчийн нэр “ ДУА-н Хонгор сумын ЗДТГ “
2. Хэрэглэгчийн байршил “ Хонгор сумын төв ”
3. Техникийн нөхцөлийн зориулалт “Хонгор сумын төвийн 5,5 км авто замын замын трассыг огтолсон цахилгаан дамжуулах шугамыг шилжүүлэх ажил ”
4. Хүчдэл 0,4; 6 кВ
5. Олгох үндэслэл 2021.09.01 ТН№1350
6. “ ДУА-н Хонгор сумын ЗДТГ ” -т дараах техникийн нөхцөлийг олгож байна.
7. Тусгай заалт: Агаарын шугамын хамгаалалтын зурвас орчимд ажил гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрэм, нэгдсэн сүлжээний дүрмийн шаардлагыг бүрэн хангаж дүрмийн шаардлага зөрчсөнөөс холбогдон гарах үүрэг хариуцлагыг ажил гүйцэтгэгч бүрэн хариуцна.
8. Хонгор сумын төвийн 5,5км замын трасст орсон шугамыг шилжүүлэх цахилгаан дамжуулах кабель шугам, агаарын шугамын тулгуурыг өндөрлөх ажлын зургыг гүйцэтгэхдээ хамгаалалтын зурвас, шугамын унжилт, овор хэмжээг цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу тооцож ажлын зураг төсөлд тусгах.
9. Шугамын трассын дагууд болон хамгаалалтын зурвас орчимд хатуу хучилттай авто зам барих зураг төсөл боловсруулах болон ажил гүйцэтгэх үед баримтлах арга хэмжээнүүд
 - 9.1. Авто зам явган замын захын далангийн налуу хучилтын шорооны хормой 35 кВ хүртэл агаарын шугамын /захын утаснаас 4 м/ хамгаалалтын зурвасаас гадагш байрлах
 - 9.2. Авто зам нь 35 кВ хүртэл шугамтай огтлолцох үед агаарын шугамын доод утаснаас авто замын хучилт хүртлэх зай хэмжээ нь /хамгийн багадаа 7м/ дүрмэнд заасан хэмжээнээс дотогш орж болохгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд 2 талын тулгуурыг өндөрлөх ажлын зардлыг тусгана.

10. Ажлын тоо хэмжээ

Огт-ын дугаар	Шугамын нэр	Хүчдлийн түвшин	Тайлбар
№1	35/6кВ Хонгор дэд станцын яч№4-өөс 6/0,4кВ АТП-131 дэд станц хүртэлх ЦДАШ	6 кВ	6 кВ-ын авто замын трасст орсон тулгуурыг зөөх
№2	6/0,4кВ-ын АТП-131 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,4кВ-ын ЦДАШ	0,4 кВ	Замын трассаас гаргах
№3	6/0,4кВ-ын АТП-131 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,22 кВ-ын ЦДАШ	0,22 кВ	Өөрчлөх шаардлагагүй.
№4	6/0,4кВ-ын ТП-52 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,4 кВ-ын ЦДАШ	0,4 кВ	Замын өндөржилтөөс хамаарч овор алдагдах өөл тулгуурыг өндөрлөх
№5	35/6кВ Хонгор дэд станцын яч№4 ЦДАШ	6кВ	6 кВ-ын ЦДАШ-н 2 цэгт огтлолцох ба овор хэмжээ алдагдахгүй бол өөрчлөх шаардлагагүй.
№6	6/0,4кВ-ын ТП-52 дэд станцаас тэжээлтэй төрийн банк, гэрэлтүүлгийн шугам	0,4 кВ	Төрийн банкы кабель шугам гэрэлтүүлгийн шугамаар явж байгаа. Тус гэрэлтүүлгийн тулгуур буухтай холбогдуулан төрийн банк руу стандартын

			шаардлага хангасан СИП утас, тулгуур барьж тэжээлийг татна. Тус хэсгийн замын трассд орсон 0,4 кВ-ын шугамыг шилжүүлэх.
№7	35/6кВ-ын Хонгор дэд станцын яч№3 Төмөр замын ЦДАШ	6кВ	Төвийн хэсэгт уурын зуухны баруун хойд хэсэгт төлөвлөсөн 350м авто замтай огтлолцсон 6кВ-ын ЦДАШ-н огтолж байгаа хэсэгт овор алдагдах бол тулгуурыг өндөрлөнө.
№8	35/6 кВ-ын Хонгор дэд станцын яч№4-өөс 6/0,4кВ-ын АТП-130 дэд станц хүртэлх ЦДАШ	6кВ	6/0,4кВ-ын АТП-130 дэд станц руу явсан 6кВ-ын ЦДАШ-н авто замын трассд орсон тулгуурыг зөөж трасс өөрчлөх
№9	35/6 кВ-ын Хонгор дэд станцын яч№4-өөс 6/0,4кВ-ын АТП-376 дэд станц хүртэлх ЦДАШ	6кВ	6/0,4кВ-ын АТП-376 дэд станц руу явсан 6кВ-ын ЦДАШ-ын авто замын трассд орсон тулгуурыг зөөж трассыг өөрчлөх, овор алдагдахаар бол тохирох тулгуур ашиглах
№10	6/0,4кВ-ын АТП-130 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,4 кВ-ын ЦДАШ	0,4 кВ	0,4кВ-ын ЦДАШ авто замын трассд таарах тул бетон тулгуур босгож тулгуурыг шинэчлэх
№11	6/0,4кВ-ын АТП-130 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,4 кВ-ын ЦДАШ	0,4 кВ	0,4кВ-ын ЦДАШ авто замын трассд таарах тул бетон тулгуур босгож тулгуурыг шинэчлэх
№12	6/0,4кВ-ын АТП-130 дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас гарсан 0,4 кВ-ын ЦДАШ	0,4 кВ	6/0,4кВ-ын АТП-130 дэд станцаас тэжээлтэй ЦДАШ-аас 6-р гудамжны айлууд гудамж дамжуулан оруулгын кабель татагдсан тул тус хэсэг бүрт СИП кабель бүхий тулгуур ашиглан давуулгыг гүйцэтгэнэ.

11. Нэмэлт арга хэмжээ

- 11.1. Инженерийн шугам сүлжээ хүн амын суурьшилтай бүсээр авто зам тавигдах тул газар эзэмшигч, инженерийн шугам сүлжээ хариуцагчид, газар олгосон болон хангагч байгууллагын зөвшөөрлийг баримтаар авч зураг төслөө боловсруулна.
- 11.2. Шугамын угсралтын ажил нь эрх бүхий этгээдийн боловсруулж хянагдсан ажлын зураг төсвийн дагуу, Тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр БУА-ыг гүйцэтгүүлсэн байх бөгөөд угсралт, туршилтын акт баримтыг бүрдүүлсэн байна.
- 11.3. Авто замын БУА нь ажлын зураг, ЦБД, ТАД, ААД, ГАБХД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэмийн шаардлагуудыг хангасан байна
- 11.4. БУА-ын явцад хангагчид хүсэлт гаргаж хяналт хийлгэнэ
- 11.5. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу шаардлагатай тохиолдолд хангагч байгууллагад захиалга өгч ажлын байр бэлдүүлж БУА-ыг гүйцэтгэнэ.

12. Энэхүү техникийн нөхцлийн 4-т тусгагдсан огтлолын цэгүүдэд шугам шилжүүлэх, тулгуур өндөрлөх ажлын зардлыг авто зам барих ажлын төсөвт тусгаж Эрчим хүчний яамнаас олгогдсон тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлнэ.

13. Хавсаргасан баримтууд

13.1.1. Албан тоот / Хонгор сумын засаг дарга, Засмал зам ХХК /

13.1.2. Санал

14. Техникийн нөхцөлийг явуулсан газар

14.1.1. Хонгор сумын ЗДТГ

14.1.2. ТБТХэлтэс

утас: 7037-7881

8855-9335

ХЯНАСАН:ТЕХНИК БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА ←

Э.ЭРДЭНЭБАТ


БОРЛУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

С.БАТБААТАР

БОЛОВСРУУЛСАН: ИНЖЕНЕР

Е.ЛХҮНДЭВ ←

БАТЛАВ. ДСЦТС ХК-ИЙН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б. БАТЖАРГАЛ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 44 / 464 – 2021 – 09

2021 оны 09 сарын 16-ны өдөр

Дархан-Уул аймаг

- | | |
|---|---------------------------------|
| 1. Хэрэглэгчийн нэр | “ ДУА-н Хонгор сумын ЗДТГазар ” |
| 2. Хэрэглэгчийн байршил | “ Хонгор сум ” |
| 3. Техникийн нөхцөлийн зориулалт | “ Гэрэлтүүлэг ” |
| 4. Хэрэгцээт (суурилуулсан) хүч чадал кВт | 22.72 |
| 5. Холбогдох хүчдэл | 380 В |
| 6. Ажлын ээлж буюу ажиллагааны горим | 24 цаг |
| 7. Хэрэглэгчийн зэрэг | 3 |
| 8. Олгох үндэслэл | 2021.09.01 ТН№1350 |
| 9. “ ДУА-н Хонгор сумын ЗДТГазар” -т дараах техникийн нөхцлийг олгож байна. | |

10. Тусгай заалт: Холболтын цэг хүртлэх хэрэглэгчийн шугам тоноглолын ашиглалт аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан бүрэн бүтэн байдал болон холбогдон гарах үүрэг хариуцлагыг хэрэглэгч бүрэн хариуцна.
11. Дархан-Уул аймаг, Хонгор сумын гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийг дараах дэд станцын 0,4кВ-ын ХБ-аас хэрэглэгч өөрийн хөрөнгөөр тоолуур төвлөрүүлсэн хайрцаг суурилуулж 380 В-ын 100А-ын ухаалаг тоолуур ачаалалдаа тохирсон автоматаар дамжуулан татагдсан цахилгаан дамжуулах кабель шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Д/д	Дэд станц	Байршил	Чадал кВт	Автомат А	Холболтын цэг
1	АТП-131	Хойд хороо Сансар, Атар, Төвийн гудамжны хэсгийн 2,3км авто зам	6.04	25	0,4кВ-ын 1-р галгааны тулгуур№2-оос ТТХ суурилуулж авах
2	ТП-52		5	25	3-р гаргалгааны тулгуур №8-аас ТТХ суурилуулж авах
3	АТП-131	Уурын зуух, Төв 0,35 км авто зам	1,68	10	0,4кВ-ын 1-р галгааны тулгуур№2-оос ТТХ суурилуулж авах
4	АТП-130	Баруун хороо хэсгийн 2,2км авто зам	7	16	0,4кВ-ын ЦДАШ-н тулгуур№1-ээс ТТХ суурилуулж авах
5	АТП-133		3	10	

12. Шинээр холболт хийж байгаатай холбогдуулан гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
13. Дамжуулагчийн хөндлөн огтлолын талбай болон шугамын трассыг зураг төслийн шатанд шийдвэрлэнэ.
14. Хэрэглээний шаардлагаас хамааруулж нөөц тэжээлийн эх үүсвэртэй байх /хуримтлуур, дотоод шаталтат эх үүсвэр, өөр дэд станцын шугамнаас холбогдох гэх мэт/ шийдлийг сонгон ажиллагааны горимыг хангагчийн Ерөнхий инженерээр хянуулж баталгаажуулснаар хэрэгжүүлэх боломжтой.
15. Хяналт хэмжилт болон бодит байдалд, эрчим хүчний чанарын үзүүлэлтүүд стандарт шаардлагыг хангахгүй нь нотлогдсон тохиолдолд хангагчид хандаж техникийн зөвлөлийн хуралд оруулах бөгөөд хурлаас гарсан шийдэрийн дагуу гарах зардлыг хангагч, эсвэл хэрэглэгч хариуцна.

16. Хэрэглэгчийн 0,4 кВ-ын шит, тэжээлийн шугам нь мөрдөгдөж байгаа Цахилгаан байгууламжийн, Техник ашиглалтын, Аюулгүй ажиллагааны, Галын аюулгүй байдлыг хангах болон Эрчим хүч хэрэглэх дүрмүүдийн шаардлагыг хангасан, ажлын зургийн дагуу, зохих зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар угсруулсан, шаардлагатай акт баримтыг бүрдүүлсэн байх ёстой.
17. Хэрэглэгчийн 0,4 кВ-ын оролтын болон салбар шитэнд:
- а. Ашиглалтын дүрэмд заасан хэмжээнд хүрсэн эсэргүүцэлтэй / 4 Ом / газардуулга хийж, хэмжилтийн актыг үйлдсэн байна.
- б. Гүйдэл ихсэлтийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фаз нойл тасралт, фазын дараалал алдагдалтаас сэргийлсэн болон хэрэглэгчийн ашиглаж байгаа тоноглолд шаардлагатай бусад хамгаалалтуудыг угсарч ажиллагааг шалгасан акт үйлдсэн байна.
18. Тооцооны хэмжих хэрэгсэл болох нарийвчлалын анги нь 1.0-оос ихгүй, стандарт хэмжил зүйн төвөөр батлагдсан хангагчаас зөвшөөрөгдсөн үзүүлэлт бүхий 380В-ын 100А-ын CL710S11 маркийн ухаалаг электрон тоолуур, ачаалалдаа тохирсон автоматыг дэд станцын 0,4кВ-ын хайрцагт угсарч монтажилна.
19. Хэрэглэгчийн угсарсан шугам, шит, цахилгаан тоноглолд холбогдох журмын шаардлагыг хангасан эсэхэд Дархан Түгээх төвийн дарга, ДХҮТ-ийн дарга, ХТЛА-ны дарга нар хяналт тавина.
20. Хэрэглэгчийн хуваарилах шитний иж бүрдэл, угсралт, тоолуурын холболт ажиллагаа, хэт ачааллаас хязгаарлах автомат, гал хамгаалагчийн тавил холболт, ачааллыг фазуудад жигд хуваарилсан байдлыг ДХҮТ-ийн даргад шалгуулж, хангагч хэрэглэгчийн төлөөлөгчид тооцооны тоолуурт лац тэмдгээ тавьж тооцооны хэрэгсэлийн ил холболтуудыг битүүмжилнэ.
21. Дархан ХҮТ-ийн гэрээний инженертэй ЦЭХ хэрэглэх гэрээ байгуулж хүчдэлд залгах захиалга өгөгдсөнөөр ЦЭХ-ээр хангагдана. Гэрээнд эзэмшлийн зааг, шитний схем, тооцоо хийх аргачлалаа хавсаргана.
22. Техникийн нөхцөлд заасан хүчин чадлыг нэмэгдүүлэх, өөрийн шитнээс бусад хэрэглэгчийг хангагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр холбохыг хориглоно.
23. Шинээр угсарсан шугам тоноглолын байршил трасс, гүйцэтгэлийн акт баримтын 1 хувийг хангагч болон тухайн орон нутгийн ГХБХБГазарт өгнө.
24. Холбогдох цэгийн техникийн үзүүлэлтүүд :
- а. Хүчдэл 380 В
- б. Ачаалалдаа тохирсон хамгаалалттай байна
25. Техникийн нөхцөл авсанаас хойш хоёр жилийн хугацаанд ЦЭХ-нд холбогдоогүй тохиолдолд уг зөвшөөрөл нь хүчингүй болно. Холболт хийгдэлгүй хоёр жил болсон, хэрэглэгчийн анхны захиалгын хүчин чадал, үйл ажиллагааны чиглэл, байршил, эзэмшигчид өөрчлөлт орсон тохиолдолд, хэрэглэгч техникийн нөхцлийг шинэчлэн авах үүрэгтэй.
26. Техникийн нөхцөлд хавсаргасан баримт бичгүүд:
- а. Тодруулах хуудас, санал
- б. Албан бичиг
27. Техникийн нөхцөл явуулсан газрууд :
- | | | |
|-------------------------------|--------|---------------------------|
| а ДУА-н Хонгор сумын ЗДТГазар | утас: | |
| б Дархан Түгээх төв | утас: | 7037-6521 |
| в ХҮТөв | утас : | 7037-6064 7037-5796, |
| г ТБТХэлтэс | утас: | 7037-7881 8855-9335 |

ХЯНАСАН:ТЕХНИК БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА ✓

БОРЛУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН: ИНЖЕНЕР

Э.ЭРДЭНЭБАТ

С.БАТБААТАР

Е.ЛХҮНДЭВ ✓